БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/166/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Баянхонгор<br>2024 оны 02 дугаар сарын 23 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Батчимэг<br>Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 17

**4.1 Ерөнхий зүйл** ..... 17

**4.2 Материаллаг байдал** ..... 18

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 18

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 18

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 19

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 19

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 20

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 22


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТӨБЦГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/69

танай___________-ны № ____________ -т

БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗЫН ДАРГА
М.ЧИНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.
- Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А08 дугаар захирамжаар дуучны цомгийн зардалд засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3,050.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6,100.0 мянган төгрөгийн 2 мотоцикл, хүүхдийн цэцэрлэгт 3,000.0 мянган төгрөгийн ширээ, сандал авсан байна.
- Тайлант хугацаанд өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр ланд-470 авто машинд 8,800.0 мянган төгрөгийн мотор, 1,400.0 мянган дугуй авч сольж тавьсан бөгөөд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай

5020256

хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2021 оны ""Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2 дахь "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасниас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх", ТӨБЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам", УСНББОУС-12 бараа материал болон оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, авто машинд сольж тавьсан сэлбэг хэрэгслийг бараа материалын тайланд үлдэгдлээр тайлагнасан нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 92.0 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 54,575,428.00 | 181,665,086.35 |
| **33** | **АВЛАГА** | 13,141,490.00 | 17,790,418.35 |
| **335** | **Бусад авлага** | 13,141,490.00 | 17,790,418.35 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,026,490.00 | 14,675,418.35 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 41,433,938.00 | 163,874,668.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,688,000.00 | 98,128,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 11,688,000.00 | 98,128,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,745,938.00 | 38,626,668.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 905,300.00 | 1,108,030.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,840,638.00 | 25,718,638.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 10,200,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 1,000,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 00.00 | 600,000.00 |
| 35600 | Мал амьтад | 25,000,000.00 | 27,120,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,267,837,517.40 | 2,109,271,425.39 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,267,837,517.40 | 2,109,271,425.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,232,405,517.40 | 2,073,839,425.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,125,479,637.10 | 1,824,439,052.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,307,948,952.87 | -440,834,869.69 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 196,514,244.68 | 280,194,244.68 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -98,514,262.65 | -148,247,077.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 143,448,840.80 | 155,601,080.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -82,183,894.94 | -103,689,970.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,603,249.82 | 45,218,374.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,742,356.36 | -31,837,086.01 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 364,908,659.00 | 635,615,859.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -119,200,937.18 | -143,661,471.95 |
| 39217 | Ном | 1,041,290.00 | 1,041,290.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 35,432,000.00 | 35,432,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 35,907,000.00 | 35,907,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -475,000.00 | -475,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 1,322,412,945.40 | 2,290,936,511.74 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| **413** | **Өглөг** | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 1,319,297,945.40 | 2,287,821,511.74 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,319,297,945.40 | 2,287,821,511.74 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 398,727,817.78 | 398,727,817.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 398,727,817.78 | 398,727,817.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 709,073,724.38 | 1,823,083,376.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 709,073,724.38 | 854,533,320.07 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 968,523,566.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 211,496,403.24 | 66,036,807.55 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,322,412,945.40** | **2,290,936,511.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 582,349,245.00 | 1,865,491,166.42 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 120,213,711.00 | 1,009,963,022.42 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 120,213,711.00 | 1,009,963,022.42 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,811,700.00 | 12,318,170.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,811,700.00 | 12,318,170.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 462,135,534.00 | 855,528,144.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,200,434.00 | 1,939,836.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,200,434.00 | 1,939,836.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 452,935,100.00 | 853,537,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 452,935,100.00 | 853,537,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 50,708.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 50,708.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 600,654,042.16 | 893,372,277.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 600,654,042.16 | 893,372,277.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 534,490,652.56 | 752,958,322.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231,141,903.00 | 348,711,407.91 |
| 210101 | Үндсэн цалин | 231,141,903.00 | 266,054,684.11 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 82,656,723.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,779,434.00 | 43,348,271.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,722,955.07 | 29,551,877.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,302,470.01 | 3,443,875.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,690,044.86 | 2,761,781.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,017.91 | 686,327.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,604,946.15 | 6,904,409.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,862,215.00 | 31,808,883.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,913,981.00 | 8,358,305.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,948,234.00 | 22,453,078.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 997,500.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,822,803.40 | 57,554,134.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,045,500.00 | 4,738,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,012,393.60 | 19,735,617.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 995,840.00 | 1,292,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 3,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 29,185,649.80 | 28,211,967.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 300,000.00 | 575,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,283,420.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,650,000.00 | 23,244,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,650,000.00 | 23,244,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,952,000.00 | 7,983,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,952,000.00 | 7,983,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,455,179.00 | 47,864,364.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,200,434.00 | 43,126,009.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 587,775.00 | 407,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 335,302.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,548,671.24 |
| 210807 | Газрын төлбөр | 108,936.00 | 106,658.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 48,732.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 169,827,118.16 | 192,443,761.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,338,740.00 | 40,043,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 2,530,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 139,488,378.16 | 149,869,861.83 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 66,163,389.60 | 140,413,954.72 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,046,096.00 | 2,730,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,548,296.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,377,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,120,000.00 | 2,730,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 19,117,293.60 | 137,683,954.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,117,293.60 | 137,683,954.72 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | -18,304,797.16 | 972,118,888.94 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,595,322.60 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,595,322.60 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,595,322.60 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -18,304,797.16 | 968,523,566.34 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **463,947,234.00** | **867,846,314.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,811,700.00** | **12,318,170.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,811,700.00 | 12,318,170.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,811,700.00 | 12,318,170.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,811,700.00 | 12,318,170.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **462,135,534.00** | **855,528,144.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,200,434.00 | 1,939,836.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,200,434.00 | 1,939,836.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 452,935,100.00 | 853,537,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 452,935,100.00 | 853,537,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 50,708.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 50,708.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **463,647,234.00** | **846,594,074.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **463,647,234.00** | **846,594,074.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **397,483,844.40** | **706,180,119.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 230,218,739.00 | 352,594,826.26 |
| 210101 | Үндсэн цалин | 230,218,739.00 | 269,938,102.46 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 82,656,723.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,779,434.00 | 43,321,781.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,571,023.87 | 29,525,387.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,302,470.01 | 3,443,875.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,841,976.06 | 2,761,781.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 459,017.91 | 686,327.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,604,946.15 | 6,904,409.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,378,215.00 | 31,808,883.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,913,981.00 | 8,358,305.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,464,234.00 | 22,453,078.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 997,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 59,711,537.40 | 58,548,864.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,725,500.00 | 4,941,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,896,393.60 | 19,735,617.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 995,840.00 | 1,292,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 3,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 29,493,803.80 | 29,003,967.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 575,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,650,000.00 | 35,044,500.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 2,650,000.00 | 35,044,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,952,000.00 | 7,983,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,952,000.00 | 7,983,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,455,179.00 | 127,804,364.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,200,434.00 | 123,066,009.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 591,275.00 | 407,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 269,102.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 172,700.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,548,671.24 |
| 210807 | Газрын төлбөр | 108,936.00 | 106,658.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 48,732.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,338,740.00 | 49,073,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,338,740.00 | 46,543,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 2,530,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66,163,389.60** | **140,413,954.72** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,046,096.00 | 2,730,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,548,296.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,377,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,120,000.00 | 2,730,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 19,117,293.60 | 137,683,954.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,117,293.60 | 137,683,954.72 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **300,000.00** | **21,252,240.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **300,000.00** | **21,252,240.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **300,000.00** | **21,252,240.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 300,000.00 | 21,252,240.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 300,000.00 | 21,252,240.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-300,000.00** | **-21,252,240.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| С01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бодлогын өөрчлөлт | | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **709,073,724.38** | **00.00** | 1,319,297,945.40 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **709,073,724.38** | **00.00** | 1,319,297,945.40 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 145,459,595.69 | 00.00 | 145,459,595.69 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **398,727,817.78** | **211,496,403.24** | **854,533,320.07** | **00.00** | 1,464,757,541.09 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -145,459,595.69 | 00.00 | 00.00 | -145,459,595.69 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 968,523,566.34 | 00.00 | 968,523,566.34 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **398,727,817.78** | **66,036,807.55** | **1,823,056,807.41** | **00.00** | 2,287,821,511.74 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 854,537,500.00 | 716,671,815.28 | 137,865,684.72 | 83.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 854,537,500.00 | 716,671,815.28 | 137,865,684.72 | 83.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 851,037,500.00 | 713,941,815.28 | 137,095,684.72 | 83.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 377,077,740.00 | 352,594,826.26 | 24,482,913.74 | 93.5 |
| 210101 | Үндсэн цалин | 271,709,720.00 | 269,938,102.46 | 1,771,617.54 | 99.3 |
| 210102 | Нэмэгдэл | 105,368,020.00 | 82,656,723.80 | 22,711,296.20 | 78.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,134,560.00 | 43,321,781.48 | 3,812,778.52 | 91.9 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
005
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,051,380.00 | 29,525,387.61 | 2,525,992.39 | 92.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,015,500.00 | 3,443,875.69 | -428,375.69 | 114.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,769,480.00 | 2,761,781.29 | 1,007,698.71 | 73.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 755,460.00 | 686,327.50 | 69,132.50 | 90.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,542,740.00 | 6,904,409.39 | 638,330.61 | 91.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,840,500.00 | 31,808,883.00 | 31,617.00 | 99.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,275,400.00 | 8,358,305.00 | -82,905.00 | 101.0 |
| 210302 | Түлш, халаалт | 22,565,100.00 | 22,453,078.00 | 112,022.00 | 99.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 997,500.00 | 2,500.00 | 99.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 60,798,800.00 | 58,548,864.50 | 2,249,935.50 | 96.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,333,100.00 | 4,941,080.00 | 392,020.00 | 92.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,456,900.00 | 19,735,617.50 | -278,717.50 | 101.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,408,800.00 | 1,292,700.00 | 116,100.00 | 91.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,500,000.00 | 3,000,000.00 | 500,000.00 | 85.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 30,500,000.00 | 29,003,967.00 | 1,496,033.00 | 95.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 575,500.00 | 24,500.00 | 95.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,409,000.00 | 37,044,500.00 | 364,500.00 | 99.0 |
| 210604 | Урсгал засвар | 37,409,000.00 | 37,044,500.00 | 364,500.00 | 99.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,369,600.00 | 7,983,000.00 | 386,600.00 | 95.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,369,600.00 | 7,983,000.00 | 386,600.00 | 95.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 217,997,900.00 | 120,866,060.04 | 97,131,839.96 | 55.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 212,451,400.00 | 116,127,705.80 | 96,323,694.20 | 54.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600,000.00 | 407,025.00 | 192,975.00 | 67.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,500.00 | 00.00 | 272,500.00 | 0.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 180,000.00 | 176,000.00 | 4,000.00 | 97.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,548,671.24 | 15,328.76 | 99.6 |
| 210807 | Газрын төлбөр | 130,000.00 | 106,658.00 | 23,342.00 | 82.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 00.00 | 300,000.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 70409400.00 | 61773900.00 | 8,635,500.00 | 87.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,409,400.00 | 59,243,900.00 | 6,165,500.00 | 90.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000,000.00 | 2,530,000.00 | 2,470,000.00 | 50.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3500000.00 | 2730000.00 | 770,000.00 | 78.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,500,000.00 | 2,730,000.00 | 770,000.00 | 78.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,500,000.00 | 2,730,000.00 | 770,000.00 | 78.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 854,537,500.00 | 854,355,770.00 | 181,730.00 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 853,537,500.00 | 853,537,600.00 | -100.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 525,858,800.00 | 853,537,600.00 | -327,678,800.00 | 162.3 |





005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 818,170.00 | 181,830.00 | 81.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 818,170.00 | 181,830.00 | 81.8 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 13.00 | 13.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **07.00** | **07.00** | 0.00 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0 |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,200,434.00** | **1,990,544.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,200,434.00** | **1,990,544.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,200,434.00 | 1,990,544.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,200,434.00 | 1,990,544.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,200,434.00 | 1,990,544.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,200,434.00 | 1,990,544.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,200,434.00 | 1,990,544.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,200,434.00 | 1,939,836.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 50,708.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжүүлэн ажилладаг сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг.

Тус байгууллага нь 2023 онд хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасаг, санхүүгийн алба гэсэн бүтэцтэйгээр нийт 21 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, тайлант онд үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 854,537.5 мянган төгрөг батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг,



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршин" гэсэн эрхэм зорилготой, "Хүний хөгжил", "Хүнс, хөдөө аж ахуйн, байгаль орчин ногоон хөгжлийн бодлого", "Эх байгаль, ногоон байгууламж", "Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлого баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах" зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга М.Чинбат, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Түмэнболд нар зурж, нярваар Н.Амартүвшин ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг мөрдөж ажилласан.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,290,936.5 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 968,523.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 13,141.4 | 17,790.4 | 4,649.0 |
| Бараа материал | 41,433.9 | 163,874.7 | 122,440.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,903,902.9 | 2,978,016.9 | 74,114.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,636,065.4) | (868,745.5) | 767,319.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,322,412.8** | **2,290,936.5** | **968,523.7** |
| Өглөг | 3,115.0 | 3,115.0 | 0.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,319,297.8 | 2,287,821.5 | **968,523.7** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,322,412.8** | **2,290,936.5** | **968,523.7** |

Авлага дансны үлдэгдэл 17,790.4 мянган төгрөг байгаа нь өвс тэжээлийн 3,115.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй анхан шатны шүүхэд шилжүүлж шүүхээс 2024 оны 6 дугаар сарын дотор авлагыг барагдуулах мэдэгдэл өгсөн байна. Мөн сумын ЗДТГ-ын барилгын зураг төсвийг 10,000.0 мянган төгрөгөөр хийлгэж авлагаар бүртгэсэн, ЗДТГ барих хөрөнгө шийдэгдээгүй, үйлдвэрчний эвлэл, НДШ, ХХОАТ-ын авлага 4,675.1 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 163,874.7 мянган төгрөг болж өмнөх оноос 122,440.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 175,074.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн засварын материалын орлого 21,878.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 76,631.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,978,016.9 мянган төгрөг болж 74,114.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 21,252.2 мянга, Баянцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/106 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 729,006.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч бүртгэсэн, өмнөх онд ОНХС-аар хийгдсэн 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч бүртгэсэн, аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор 5,580.0 мянга, Баянцагаан сумын Соёлын төвөөс 24,000.0 мянган төгрөгийн авто машин, багийн зааланд 5,615.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, аймгийн ИТХ-ын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 14/28 дугаар тогтоолоор 10,066.9 мянган төгрөгийн хуучин соёлын төвийн барилга, аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

13/08 дугаар тогтоолоор 721,272.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 198,727.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж үнэлж буцааж орлого авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 3,115.0 мянган төгрөг байгаа нь Сум дундын ойн ангид 2021 онд үүссэн өвс тэжээлийн өглөгийг барагдуулаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 968,523.7 мянган төгрөгөөр өсөж 2,287,821.5 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 504,563.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 504,563.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1 удаа тодотгол хийж 348,974.2 мянган төгрөгөөр өсгөж орон нутгийн төсвөөс 853,537.5 мянга, өөрийн үйл ажиллагаанаас 1,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 853,537.5 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 853.355.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөг төлөвлөснөөс 818.2 мянган төгрөг төвлөрүүлж, 137,683.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 716,671.8 мянган төгрөг буюу 83.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 137.683.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсөв** | | | | | |
| 1 | 70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 854,537.5 | 716,671.8 | 137,865.7 | 92.9% |
| 1.1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 443,029.9 | 411,366.1 | 31,663.8 | 97.7% |
| 1.2 | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 101,146.8 | 98,821.6 | 2,325.2 | 90.8% |
| 1.3 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 65,409.4 | 59,423.9 | 5,985.5 | 54.5% |
| 1.4 | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 211,451.4 | 115,342.3 | 96,109.1 | 95.1% |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.5 | 82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал | 30,500.0 | 29,003.9 | 1,496.1 | 90.5% |
| 1.6 | 80802 Ажил олгогчоос тэтгэмж | 3,000.0 | 2,714.0 | 286.0 | 83.9% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна. (мянган төгрөг)

| № | Санхүүжилт олгосон байгууллага | Орлогын төрөл | Санхүүжилтийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс | Мал тооллогын зардал | 1,214.2 |
| 2 | Баянхонгор аймгийн ОНХС | “Хамтдаа шийдье” аяны зардал | 725.6 |
| 3 | Сэргээгдэх эрчим хүчний нарны толь | Дуудлага худалдааны орлого | 10,000.0 |
| 4 | Хайгуулын компани | Барьцаа хөрөнгө | 1,500.0 |
| 5 | Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж | 50.7 |
| | **Нийт дүн** | **-** | **12,764.9** |

Сэргээгдэх эрчим хүчний нарны толийг дуудлага худалдаагаар борлуулж 10,000.0 мянган төгрөгийг хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлж, хайгуулын компанийн байршуулсан барьцаа төлбөрийг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 22,453.1 мянга, гэрэл цахилгааны зардалд 8,275.4 мянга, цэвэр, бохир усны зардалд 1,000.0 мянга, шатахууны зардалд 19,456.9 мянган төгрөг батлагдаж “Бэст хонгор” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Петровис" ХХК-тай шатахууны гэрээ, "ЭБЦТС-Эрчим хүч" Өвөрхангай аймаг дахь ЦТХХК-тай цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2/111 дугээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсөв 854,500.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 854,500.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,817.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,972.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар дуучин М.Түмэнсайханы цомгийн зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 154 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 42 тушаал, захирамж байршуулахаас 24 тушаал, захирамжийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 122,818.2 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 32,552.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсар үеийн аудитыг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд хийсэн бөгөөд бараа материалын тайланг буруу гаргасантай холбоотой залруулах зөвлөмжийг хүргүүлж санхүүгийн тайланд залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 33.061.7 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 32.189.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага өгч, 871.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлж ажиллан биелэлтийг Баянцагаан сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны 2/94 дүгээр албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 871.9 | 1 | 871.9 | 100 |
| Албан шаардлага | 4 | 32.189.4 | 4 | 32.189.4 | 100 |
| **Нийт дүн** | **5** | **33.061.7** | **5** | **33.061.7** | **100** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 313.6 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үйлдвэрчний эвлэлээс авах авлагыг 229.8 мянган төгрөгөөр илүү, ХХОАТ-ын авлагыг 83,8 мянган төгрөгөөр дутуу тусгасан.

Аудитаар нийт 52,852.2 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 1,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 51,852.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 20,300.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21,527.7 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар дуучин М.Түмэнсайханы цомгийн зардалд засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 1,000.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагчаар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3,050.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6,100.0 мянган төгрөгийн 2 мотоцикл, цэцэрлэгт 3,000.0 мянган төгрөгийн ширээ, сандал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны “”Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, цаашид тоног төхөөрөмж бэлтгэхгүй байх албан шаардлагыг өгөв.

**5.2 Албан шаардлага**

5.2.2. Тайлант хугацаанд Ланд 470 авто машинд 8,800.0 мянган төгрөгийн мотор, 1,400.0 мянган дугуй авч сольж тавьсан бөгөөд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", ТӨБЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана", УСНББОУС-12 бараа материал болон оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сэлбэг хэрэгслийн данснаас зарлагадаж цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг өгөв.

5.2.3. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 42 тушаал, захирамж байршуулахаас 24 тушаал, захирамжийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 122,818.2 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 32,552.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 313.6 | - | - | 1 | 313.6 | 1 | 313.6 | - | - |
| Дүн | **1** | **313.6** | **-** | **-** | **1** | **313.6** | **1** | **313.6** | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар дуучин М.Түмэнсайханы цомгийн зардалд засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | - | - | - | - |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3,050.0 мянган төгрөгийн үнэ бүхий 6,100.0 мянган төгрөгийн 2 мотоцикл, цэцэрлэгт 3,000.0 мянган төгрөгийн ширээ, сандал авсан нь Сангийн сайдын 2021 оны “”Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь заалтыг зөрчсөн. | 1 | 9,100.0 | - | - | 1 | 9,100.0 | - | - |
| Тайлант хугацаанд Ланд 470 авто машинд 8,800.0 мянган төгрөгийн мотор, 1,400.0 мянган дугуй авч сольж тавьсан бөгөөд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан нь УСНББОУС-12 бараа материал болон оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна | 1 | 10,200.0 | | | 1 | 10,200.0 | | |
| Дүн | **3** | **20,300.0** | **1** | **1,000.0** | 2 | 19,300.0 | - | - |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 42 тушаал, захирамж байршуулахаас 24 тушаал, захирамжийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 122,818.2 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 32,552.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 32,552.2 | - | - | 1 | 32,552.2 | - | - |
| Дүн | **1** | **32,552.2** | **-** | **-** | **1** | **32,552.2** | **-** | **-** |

-----------oOo-----------



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр                Дугаар АА/А0571121 БНА-2024/166/НА-СТА-ТШЗ                Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08 дугаар захирамжаар дуучин М.Түмэнсайханы цомгийн зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин зориулалт бусаар зарцуулсан 1,000,000 (нэг сая) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж,

5050189

Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Чинбат, нягтлан бодогч Г.Түмэнболд нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417143544
БЮА0067 9007423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 157/А0571121 БНА-2024/166/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр ланд-470 авто машинд 8,800,000 төгрөгийн мотор, 1,400,000 төгрөгийн дугуй авч сольж тавьсан боловч санхүүгийн тайlанд сэлбэг хэрэгслийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, ТӨБЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.13 дахь “Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана”, УСНББОУС-12 бараа материал болон Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр

5040177

зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн сэлбэг хэрэгслийн данснаас зарлагадаж цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Чинбат, нягтлан бодогч Г.Түмэнболд нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417143544
ВЮА0067 9007423

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 158/А0571121 БНА-2024/166/АО-СТА-Т023 Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгөөс багийн эмч нарт нэг бүр нь 3,050,000 төгрөгийн үнэ бүхий 6,100,000 төгрөгийн 2 мотоцикл, хүүхдийн цэцэрлэгт 3,000,000 төгрөгийн ширээ, сандал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны “”Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу зарцуулах, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын

5040478

хамт 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянцагаан сумын Засаг дарга Н.Гансүх, Засаг даргын Тамгын газрын дарга М.Чинбат, нягтлан бодогч Г.Түмэнболд нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

6417143544

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 159/А0571121 БНА-2024/166/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 7 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 42 тушаал, захирамж байршуулахаас 24 тушаал, захирамжийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 122,818,240 төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 32,552,240 төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040433

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, хамтран ажиллах, худалдах худалдан авах гэсэн 7 гэрээ, 24 тушаал, зарлагын 32,552,240 төгрөгийн 3 гүйлгээг бүрэн байршуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга М.Чинбат, нягтлан бодогч Г.Түмэнболд нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[1]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БАТЧИМЭГ

[1] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно